



ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

0022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 1149

Шивээговь сум

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээх худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 350 дугаар “Тэрбум мод хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4.3 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Сумын 2022 оны төсөв батлах тухай” 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу шаардагдах зардлыг сумын “Байгаль хамгаалах, орчны бохирдлыг бууруулах-хоггүй сум” арга хэмжээний зардлаас 20,000,000 (хорин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Арга хэмжээнд зарцуулагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, баримт бичгийн бүрдлийг ханган ажиллахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш), Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (Ц.Замбага) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д, ажлыг чанартай зохион байгуулж, хагас бүтэн жилээр тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Ч.Сугармаа)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П. ГАНЧИМЭГ



42122 166